

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголросцветмет ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/30/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Улаанбаатар хот	Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
2024 он	Аудитор: Ж.Бүжинханд Утас: 261628 Цахим хаяг: bujinkhandj@audit.gov.mn
	Б энд С аудит ХХК-ийн захирал: Д.Заяажаргал Утас: 99050268 Цахим хаяг: bcauditllc@gmail.com
	Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 99075081 Цахим хаяг: bcauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 071827  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголросцветмет ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монголросцветмет ТӨҮГ тайлант онд үйл ажиллагааны шаардлагаар Хэнтий аймгийн Дархан сумын Баргилт-1 хаягт шинээр 50 га газрыг нөөц газар зориулалтаар, Төмрийн баяжмалыг хорголжлох үйлдвэр, нойтон баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж барих зориулалтаар 26,7 га газар, Дорноговь аймгийн Иххэт сумын нутаг дэвсгэрт байрлах Зүүн цагаан дэл хэсэгт Уул уурхайн тэсэрч дэлбэрэх бодисын агуулах зориулалтаар ашиглах 1 га газруудыг шинээр авч, газрын гэрчилгээ, гэрээ, кадастрыг гаргуулан авсан байна.

Монголросцветмет ТӨҮГ нь 2023 онд 5.1 сая куб метр хөрс хуулж, 1,401.8 мянган тонн төмрийн хүдэр олборлон, хуурай соронзон аргаар 52 хувийн агуулгатай төмрийн хүдрийн хуурай баяжмал 448.5 мянган тонныг, нойтон соронзон сепарацийн аргаар 65 хувийн агуулгатай төмрийн хүдрийн нойтон баяжмал 215.8 мянган тонныг тус тус үйлдвэрлэсэн, мөн шинээр үйлдвэрлэлд нэвтрүүлсэн 50 хувийн агуулгатай цайрын баяжмал 1.4 мянган тонныг үйлдвэрлэж, алт 9.8 килограммыг олборлосон байна.

## **Аудитын гол асуудал**

Монголросцветмет ТӨҮГ тайлант онд 25,462.5 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, баталсан төлөвлөгөөний биелэлт 104.3 хувьтай байна.

Тайлант оны эхний хагас жилд 1,500.0 сая төгрөгийн ногдол ашгийн төлбөрийг төлсөн бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дугаар тогтоолын дагуу 2022 оны ногдол ашгийн 666.7 сая төгрөгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Сангийн яамны 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн №03/8213 албан бичгээр өмнөх жилүүдэд хүлээсэн алдагдал, гаргасан зардлыг ногдол ашгийн төлбөрт суутган тооцох боломжгүй гэсэн чиглэл ирүүлсэн тул 2021 оны ногдол ашгийн 23,383.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг санхүүгийн тайланд илэрхийлсэн байна.

Засгийн газрын шийдвэрийн дагуу “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн нэгжийн үйл ажиллагааны болон орон нутгийн ард иргэд, байгууллагыг хэрэглээний ус, дулаанаар хангасан нийт 15,670.9 сая төгрөгийн зардлыг дээрх ногдол ашгийн төлбөрт дүйцүүлэн тооцуулах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрдэнэс Монгол ХХК-д хүргүүлсэн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд тус үйлдвэр 5 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 95 хувийн хэрэгжилттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	229,532,529.58	5,126,228,646.29
1.1.2	Дансны авлага	1,912,618,901.19	2,357,114,856.28
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	13,757,176,189.41	8,895,553,848.66
1.1.4	Бусад авлага	420,891,837.34	3,715,922,385.88
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	648,251,993.05	
1.1.6	Бараа материал	115,623,459,837.28	141,714,154,040.36
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	45,708,484,326.33	118,309,274,200.61
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>178,300,415,614.18</b>	<b>280,118,247,978.08</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	123,434,239,086.48	137,148,574,854.53
1.2.2	Биет бус хөрөнгө	5,763,061,562.36	5,889,211,327.34
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	7,739,323,772.72	10,752,024,140.87
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	667,703,007.39	34,941,805.24
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	25,633,825,467.94	32,012,967,998.11
1.2.9	Дуусаагүй барилга	940,178,702.54	1,033,778,702.54
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>164,178,331,599.43</b>	<b>186,871,498,828.63</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>342,478,747,213.61</b>	<b>466,989,746,806.71</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	37,792,002,431.37	40,712,224,709.11
2.1.1.2	Цалингийн өглөг	2,110,167,301.82	4,220,676,858.72
2.1.1.3	Татварын өр	5,564,257,830.88	30,737,306,320.43
2.1.1.4	НДШ-ийн өглөг	3,453,809,226.57	2,830,342,571.50
2.1.1.5	Богино хугацаат зээл	15,914,036,865.41	34,094,224,068.30
2.1.1.6	Хүүгийн өглөг	6,729,599.31	321,297,502.93
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	24,883,320,000.00	23,383,320,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	66,794,968,857.56	124,277,295,395.11
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	1,996,688,010.56	1,898,191,514.48
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	5,170,072,440.87	382,484,124.71
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>163,686,052,564.35</b>	<b>262,857,363,065.29</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/		355,803,687.56
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		8,800,000.00
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>364,603,687.56</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>163,686,052,564.35</b>	<b>263,221,966,752.85</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Төрийн өмч	1,226,788,000.00	1,226,788,000.00
2.3.2	Хувийн өмч		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	52,657,728,803.97	52,631,132,657.47
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,641,413,040.00	2,641,413,040.00
2.3.9	Тусгай зориулалтын нөөц сан	18,100,000,000.00	
2.3.10	Хуримтлагдсан ашиг	104,166,764,805.29	147,268,446,356.39
2.3.10.1	Тайлангийн үеийн	1,333,373,364.70	25,462,468,363.98
2.3.10.2	Өмнөх үеийн	102,833,391,440.59	121,805,977,992.41
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>178,792,694,649.26</b>	<b>203,767,780,053.86</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>342,478,747,213.61</b>	<b>466,989,746,806.71</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**  
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>87,995,662,533.96</b>	<b>216,354,837,575.16</b>
2	Борлуулалтын өртөг	44,912,426,527.37	102,975,904,150.08
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>43,083,236,006.59</b>	<b>113,378,933,425.08</b>
4	Түрээсийн орлого	260,019,415.96	257,196,961.36
5	Хүүгийн орлого	337,486,027.39	19,544,156.68
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	4,501,855,426.69	4,610,408,754.08
9	Борлуулалт, маркетингийн зардал	15,227,564,941.70	54,333,185,612.94
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,198,666,350.78	12,654,976,352.42
11	Санхүүгийн зардал	352,335,236.01	2,836,530,175.26
12	Бусад зардал	18,025,470,483.05	12,373,713,783.85
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	5,608,732,520.44	144,327,688.87
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	(2,158,120,001.48)	(191,337,910.85)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз ( гарз )		
17	Бусад ашиг ( алдагдал )		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>9,829,172,384.05</b>	<b>36,020,667,150.75</b>
19	Орлогын татварын зардал	8,495,799,019.75	10,558,198,786.77
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>1,333,373,364.30</b>	<b>25,462,468,363.98</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>1,333,373,364.30</b>	<b>25,462,468,363.98</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз ( гарз )		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>1,333,373,364.30</b>	<b>25,462,468,363.98</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>		

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,226,788,000.00</b>	<b>52,657,728,803.97</b>	<b>20,741,413,040.00</b>	<b>138,260,677,401.28</b>	<b>212,886,607,245.25</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				- 10,543,965,960.69	- 10,543,965,960.69
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,226,788,000.00</b>	<b>52,657,728,803.97</b>	<b>20,741,413,040.00</b>	<b>127,716,711,440.59</b>	<b>202,342,641,284.56</b>
5	Өмчид гаргасан өөрчлөлт					-
6	Зарласан ногдол ашиг				(24,883,320,000.00)	(24,883,320,000.00)
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )				1,333,373,364.70	1,333,373,364.70
9	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,226,788,000.00</b>	<b>52,657,728,803.97</b>	<b>20,741,413,040.00</b>	<b>104,166,764,805.29</b>	<b>178,792,694,649.26</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(18,100,000,000.00)	18,279,303,720.62	179,303,720.62
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,226,788,000.00</b>	<b>52,657,728,803.97</b>	<b>2,641,413,040.00</b>	<b>122,446,068,525.91</b>	<b>178,971,998,369.88</b>
12	Бусад дэлгэрэнгүй орлого					-
13	Өмчид гаргасан өөрчлөлт					-
14	Зарласан ногдол ашиг				(666,686,680.00)	(666,686,680.00)
15	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )				25,462,468,363.98	25,462,468,363.98
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(26,596,146.50)		26,596,146.50	-
17	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,226,788,000.00</b>	<b>52,631,132,657.47</b>	<b>2,641,413,040.00</b>	<b>147,268,446,356.39</b>	<b>203,767,780,053.86</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**  
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>112,904,858,614.91</b>	<b>286,015,399,879.47</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	90,881,007,301.76	278,716,042,151.09
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	35,577,989.00	85,820,286.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	21,988,273,324.15	7,213,537,442.38
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>131,969,702,789.58</b>	<b>274,612,619,574.75</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	49,697,591,509.65	58,824,250,028.27
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,561,091,487.60	17,675,219,292.38
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	13,205,527,782.14	32,271,023,570.51
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	22,599,200,028.40	34,148,791,489.31
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	22,505,697,290.52	98,249,083,551.92
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	343,336,947.73	2,528,690,155.09
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,780,294,450.54	14,154,674,208.16
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	189,042,248.00	323,582,344.27
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,087,921,045.00	16,437,304,934.84
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(19,064,844,174.67)</b>	<b>11,402,780,304.72</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>303,734,424.65</b>	<b>19,383,132.24</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	303,734,424.65	19,383,132.24
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>68,978,090,645.30</b>	<b>22,805,238,843.17</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	68,628,672,132.80	22,619,756,349.02
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	349,418,512.50	185,482,494.15
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(68,674,356,220.65)</b>	<b>(22,785,855,710.93)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>35,856,700,000.00</b>	<b>23,275,213,040.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	35,856,700,000.00	23,275,213,040.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>20,189,008,278.49</b>	<b>6,900,380,104.65</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	20,189,008,278.49	4,733,693,424.65
3.2.4	Төлсөн ногдол ашиг		2,166,686,680.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>15,667,691,721.51</b>	<b>16,374,832,935.35</b>
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(5,810,504,425.23)	95,061,412.43
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(66,261,004,248.58)</b>	<b>4,896,696,116.71</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>66,490,536,778.16</b>	<b>229,532,529.58</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>229,532,529.58</b>	<b>5,126,228,646.29</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**  
**2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр**

/төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 оны Гүйцэтгэл	2023 он		Биелэлт /харьцуулалт/, %	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт ба борлуулалт</b>						
1.1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</b>						
	Хайлуур жоншны бүтээгдэхүүн үйлдвэрлэл	мян.тн	0.4	-	-		
	Төмрийн баяжмалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл	мян.тн	444.2	631.0	664.3	(33.3)	1.1
	Цайрын баяжмалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл	мян.тн	5.9	3.6	1.4	2.2	0.4
	Алт олборлолт	кг	29.1	67.5	9.8	57.7	0.1
1.2	<b>Бүтээгдэхүүн борлуулалт</b>					-	
	Хайлуур жоншны бүтээгдэхүүний борлуулалт	мян.тн	0.5	-	0.6	(0.6)	
	Төмрийн баяжмалын бүтээгдэхүүний борлуулалт	мян.тн	260.1	780.3	730.4	50.0	0.9
	Цайрын баяжмалын бүтээгдэхүүний борлуулалт	мян.тн	1.7	4.2	5.6	(1.4)	1.3
	Төмрийн хүдрийн борлуулалт	мян.тн	317.3	673.0	115.7	557.3	0.2
	Алтны борлуулалт	кг	29.1	67.5	9.8	57.7	0.1
2	<b>Нийт борлуулалтын орлого</b>	<b>мян.төг</b>	<b>98,703,755.8</b>	<b>230,729,648.0</b>	<b>221,241,987.4</b>	<b>9,487,660.6</b>	<b>1.0</b>
2.1	Үүнд: ФФ-95 флотацын баяжмалын борлуулалт	мян.төг	155,249.6	255,190.0	546,864.4	(291,674.4)	2.1
2.2	ФК-75 металлургийн баяжмалын борлуулалт	мян.төг	202,464.8	-	141,489.2	(141,489.2)	
2.3	Fe-65 төмрийн нойтон баяжмалын борлуулалт	мян.төг	16,658,156.1	42,570,824.1	71,044,120.1	(28,473,296.1)	1.7
2.4	Fe-52 төмрийн хуурай баяжмалын борлуулалт	мян.төг	38,058,035.4	118,105,427.3	115,308,478.0	2,796,949.3	1.0
2.5	Zn-50 цайрын баяжмалын борлуулалт	мян.төг	5,241,261.0	12,108,452.9	17,433,155.8	(5,324,702.9)	1.4
2.6	Төмрийн хүдрийн борлуулалт	мян.төг	20,673,820.4	42,487,508.9	9,706,612.3	32,780,896.6	0.2
2.7	Алтны борлуулалт	мян.төг	5,505,721.3	11,812,675.0	2,174,117.7	9,638,557.3	0.2
2.8	Бусад орлого	мян.төг	12,209,047.3	3,389,569.8	4,887,149.9	(1,497,580.0)	1.4
3	<b>Нийт зардал</b>	<b>мян.төг</b>	<b>164,162,550.5</b>	<b>275,389,603.4</b>	<b>236,490,601.6</b>	<b>38,899,001.8</b>	<b>0.9</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	8,551,001.6	10,020,021.6	25,351,457.1	(15,331,435.5)	2.5
	Нийгмийн хариуцлагын хүрээний зардал	мян.төг	6,480,020.5	8,564,551.2	6,822,368.9	1,742,182.3	0.8

4	Татварын өмнөх ашиг	мян.төг	9,829,172.4	29,585,937.7	36,020,667.2	(6,434,729.5)	1.2
5	Цэвэр ашиг	мян.төг	1,333,373.4	24,368,728.8	25,462,468.4	(1,093,739.6)	1.0
6	Төсөвт төлөх татвар, шимтгэл	мян.төг	61,373,939.9	56,028,859.2	78,145,434.5	(22,116,575.3)	1.4
6.1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	мян.төг	9,443,917.1	5,217,208.9	9,504,918.3	(4,287,709.4)	1.8
6.2	Нэмэгдсэн өртгийн албан татвар	мян.төг	11,459,976.9	9,265,654.3	17,520,014.8	(8,254,360.5)	1.9
6.3	АМНАТ	мян.төг	10,387,648.9	21,400,533.4	24,717,147.5	(3,316,614.1)	1.2
6.4	Ус ашигласны төлбөр	мян.төг	1,047,809.6	1,368,068.1	2,151,774.4	(783,706.4)	1.6
6.5	Газрын төлбөр	мян.төг	307,823.4	401,234.7	249,405.6	151,829.1	0.6
6.6	Галт зэвсгийн албан татвар	мян.төг	810.0	991.0	930.0	61.0	0.9
6.7	Агаарын бохирдлын төлбөр	мян.төг	2,223.0	1,380.3	1,984.5	(604.2)	1.4
6.8	Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	20,551.7	27,341.6	26,059.0	1,282.7	1.0
6.9	Гадаадын ажиллах хүч ажиллуулсны татвар	мян.төг		17,600.0		17,600.0	
6.10	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	мян.төг	13,220,470.1	11,795,719.4	17,141,490.0	(5,345,770.6)	1.5
6.11	Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	209,918.1	233,271.5	260,440.3	(27,168.8)	1.1
6.12	ХХОАТ	мян.төг	4,786,963.1	6,299,856.1	6,253,128.5	46,727.6	1.0
6.13	Бусад татвар	мян.төг	10,485,828.0		318,141.6	(318,141.6)	
7	Ажиллагсдын дундаж хүний тоо	хүн	1,640.0	1,756.0	1,634.0	122.0	0.9
8	Цалингийн сан	мян.төг	58,715,615.4	80,687,719.9	68,685,170.1	12,002,549.7	0.9
9	Ажиллагсдын сарын дундаж цалин	төг	2,984,427.0	3,833,510.1	3,500,975.0	332,535.1	0.9
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.8	0.8	0.8	0.0	1.0
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	54,434,069.9	60,699,296.3	36,341,726.2	24,357,570.2	0.6
12	Нийт авлага	мян.төг	2,324,417.2	1,772,939.5	14,968,591.6	(13,195,652.1)	8.4
13	Нийт өглөг	мян.төг	163,686,052.6	56,421,809.7	263,221,966.8	(206,800,157.0)	4.7
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	163,686,052.6	56,219,802.0	262,857,363.1	(206,637,561.1)	4.7
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг		202,007.7	364,603.7	(162,595.9)	1.8

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,549.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 11,524.7 сая төгрөгийн 7 алдааг залруулж, 24.4 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дансны ангиллыг журмын дагуу хийгээгүйгээс санхүүгийн байдлын тайлангийн болон орлогын тайлангийн үзүүлэлтүүд үнэн зөв илэрхийлэгдээгүй	6	9,253,371.7			6	9,253,371.7	6	9,253,371.7				
Хойшлогдсон татварын хөрөнгө дансны эхний, эцсийн үлдэгдлийг хянаж үзэхэд тооцооллыг журмын дагуу хийгээгүйгээс хойшлогдсон татварын хөрөнгийг илүү тайлагнасан	4	2,271,069.2			4	2,271,069.2	4	2,271,069.2				
Тус компанийн ХААН банк дахь 5876094463 тоот багц гүйлгээ дамжуулах дансны үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	255.3	1	255.3			1	255.3				
Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд 24.5 сая төгрөгийн орлогыг тайлагнасан боловч орлогын дэлгэрэнгүй тайланд тусгаагүй	1	24,454.6	1	24,454.6					1	24,454.6	1	24,454.6
Дүн	12	11,549,150.8	2	24,709.9	10	11,524,440.9	11	11,524,696.2	1	24,454.6	1	24,454.6

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

Аудитаар нийт 631.0 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 52.2 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 519.4 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 59.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зүүн цагаан дэлийн танилцуулга, контентын зардалд 19.0 сая төгрөг, Эрдэс баялгийн тойм сэтгүүлд байгууллагын танилцуулга нийтлүүлэх зардалд 33.0 сая төгрөг, нийт 52.0 сая төгрөгийг зарцуулсан	1	52,000.0	1	52,000.0								
Бор-Өндөр УБҮ-ийн орон сууцны төлбөрийн тооцоог хянахад ажиллагсад, оршин суугчдын илүү төлсөн мөнгийг харилцагч тус бүрээр өр төлбөр үүсгэн бүртгээгүй, нийт дүнгээр 1 харилцагч дээр өглөгөөр бүртгэсэн, авлагын сөрөг үлдэгдэлтэй түүвэрлэн шалгахад нэр бүхий 1 харилцагчийн төлсөн 0.2 сая төгрөгийг орлогоор бүртгээгүй	1	245.0	1	245.0								
Байгууллагын дүрэмд заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК, ТӨҮГ-ын захиралтай "Онцгой нөхцөлт хөдөлмөрийн гэрээ"-г байгуулаагүй, 2022 оны ТӨБЗГ-тай байгуулсан гэрээг дүгнэж, урамшуулал олгох шийдвэр ирээгүй байхад хэрэгжих хугацаа дууссан гэрээний заалтыг үндэслэн жилийн эцсийн урамшуулалд 69.4 сая төгрөг, 2023 оны сар, улирлын урамшуулалд 72.5 сая төгрөг, нийт 141.9 сая төгрөгийг газрын захиралд олгосон	1	141,998.7			1	141,998.7						
Газрын захирлын А/251 дүгээр тушаалаар Стандарт Алт Монгол ХХК-аас авах авлагыг барагдуулах зорилгоор 236.0 сая төгрөгөөр Nissan patrol Y62 /09-51 УНИ/ маркийн суудлын автомашиныг авч, "Шижир Алт" салбарын балансад бүртгэсэн гэх боловч авлага дансны эхний үлдэгдэлд тус байгууллагаас авах авлага байхгүй, Шижир алт салбарын дотоод тооцоог нэмэгдүүлж, Бор өндөр салбарын дотоод тооцоог бууруулах бичилт хийсэн, зохих байгууллагаас зөвшөөрөл аваагүй	1	236,000.0			1	236,000.0						
Бор-Өндөр салбар нь захирлын тушаалгүйгээр 135.6 сая төгрөгийн балансын шагнал болон сар бүрийн урамшуулал, мөн салбарын захирал нь өөртөө тушаал гаргаж 5.8 сая	1	141,385.4			1	141,385.4						

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийн жилийн эцсийн үр дүнгийн урамшуулал, нийт 141.4 сая төгрөгийг олгосон.												
Тендер шалгаруулахгүйгээр Аксис оф ворлд ХХК-тай MR-2023-06-20 тоот вагон түрээсийн гэрээг байгуулсан. Тус гэрээ нь нийлүүлэгч талд илт давуу байдал олгосон, 300 вагоны 1 жилийн ашиглалтын төлбөр болон 2 сарын барьцаа төлбөрт (24,098.6 сая) төгрөгийг төлсөн боловч тайлант жилд 100 хүртэлх вагон ашигласан, вагон хүлээлцсэн акт ирүүлээгүй, вагон түрээсийн 1 өдрийн төлбөр зах зээлийн үнээс өндөр	1	.			1							
Ашиглаж буй Санхүүгийн Даймонд программ нь салбар тус бүр дээрээ тусдаа баазтай, ERP программаар нэгтгэл хийдэг гэх боловч орлого зарлагын данс давхацсан, мэдээлэл авах боломж муу, салбар тус бүрийн баазаас мэдээллийг татан авч мэдээллийг нэгтгэхэд хүндрэлтэй, санхүүгийн тайлангийн болон орлого, зардлын дансны кодчиллыг дансны нэгдсэн төлөвлөгөөний дагуу хийгээгүй, борлуулалтын орлогын дансанд өртгийн данс холилдсон, авлага, өр төлбөрийн зарим данстуудад туслах журнал хөтлөөгүйгээс авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч бүрээр тулгах боломжгүй, санхүүгийн тайланд үлдэгдэл буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй	1				1							
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний тайланг үндэслэн хөрөнгө тус бүрээр дэлгэрэнгүй тайлан хөтөлдөггүй, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн дагуу НӨАТ-ыг дараагийн жилүүдэд хувь тэнцүүлэн хасаж буй хөрөнгийн тооцооллд дэлгэрэнгүй тайлан хөтлөөгүй, жолоочийн тооцооны хуудас, шатахууны илүү дутууг тооцоолдоггүй, орон нутагт ажиллах албан томилолтын зардлыг олгохдоо хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэх боломжтой газруудад шатахууны зардал олгож, өөрийн унаагаар зорчиж байна.	1					1						
Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор "165 айлын орон сууцыг эзэмшүүлэх, түр хугацаагаар эзэмшүүлэх журам"-аар сонгон шалгаруулалт хийж, Захиргаа 15, Бор-Өндөр УБҮ 80, Шижир-Алт 20 нийт 115 орон сууцыг хуваарилахаар шийдвэрлэсэн боловч Захиргаа 48, Бор-Өндөр 89, Шижир-Алт 9 гэрээ байгуулж, шаардлага хангасан зарим ажилчдад олгоогүй, нийт 39 ажилтанд сонгон шалгаруулалтгүйгээр орон сууц олгосон	1					1						
Үндсэн хөрөнгөд хэсэгчилсэн тооллого хийхэд 35.0 сая төгрөгийн үнэ бүхий Бор-Өндөр салбарын дансанд бүртгэлтэй Ланд-100 авто машин нь бодитоор оршин байхгүй	1	35,000.0					1	35,000.0				
Дүн	10	606,629.1	2	52,245.0	5	519,384.1	3	35,000.0				